

АЛТАЙ ХЭЛНИЙ ОНОЛ БА ТҮРЭГ, МОНГОЛ ХЭЛНИЙ ХЭЛ ЗҮЙН ХАРЬЦАА

Л.Болд*

Товч агуулга: Зохиогч энэхүү илтгэлдээ алтай хэлний онолыг зөвшөөрөгчид хийгээд үл зөвшөөрөгчдийн байр суурийн талаар тодорхой баримтад түшиглэн өгүүлээд, улмаар түрэг, монгол хэлний хэл зүйн харьцааны асуудлыг уг хэлнүүдэд буй зүг чиг заах тийн ялгалын айгаар төлөөлүүлэн, эртний түрэг, монгол хэл хийгээд орчин цагийн түрэг, монгол хэлний жишээ баримтаар тодруулан үзээд дараах дүгнэлтэд хүрчээ. Үүнд, алтай хэл судлалын хүрээнд багагүй чухал байр эзэлдэг түрэг, монгол хэлний харьцааны асуудлыг уг хэлнүүдэд буй нийтлэг зүйлийг нь гол болгон гарал зүйнхээ хувьд холбоотой гэх, эсвэл уг нийтлэг зүйлийг нь нэг хэлнээсээ нөгөө хэлэндээ үзүүлсэн нөлөөгөөр тайлбарласаар нэлээд хугацаа өнгөрч, энэ хоёр эсрэг тэсрэг онолын аль нэгийг зөвшөөрч, нөгөөг нь үгүйсгэсэн бүтээл туурвил гарсаар байна. Гэвч энд зохиогчийн задлан шинжилсэн баримтаас үзэхэд түрэг, монгол хэлний харьцааг уг хоёр эсрэг тэсрэг онолын аль нэгийг нь баримтлан нөгөөг нь үгүйсгэн тайлбарлах нь учир дутагдалтай, уг хоёр онолыг тэгш харгалзан үзэх шаардлагатай нь тодорхой байна. Энэ нь эдгээр эсрэг тэсрэг онолууд нь харилцан бие биеэ үгүйсгэсэн боловч бас харилцан бие биеэ нөхсөн шинжтэй гэдгийг харуулж байна. Өөрөөр хэлбэл, түрэг, монгол хэл нь гарал зүйнхээ үүднээс холбогдож болох авч бас биедээ үлэмж нөлөө үзүүлсэн, гэхдээ зөвхөн түрэг хэл монгол хэлэнд биш бас орчин цагийн түрэг хэлнүүдийг бүрэлдэн тогтоход монгол хэл багагүй чухал үүрэг гүйцэтгэжээ хэмээн дүгнэжээ.

Үндсэн хэсэг: Монгол хэл судлалын үе үеийн ахмад эрдэмтдийн эрдэм судалгаа шинжилгээний ажлын нэг үндсэн чиглэл бол алтай хэлнүүдийн өөр хоорондын харьцаа хийгээд монгол төрөл хэлнүүдийг

* ШУА-ийн Хүмүүнлэгийн ухааны бага чуулганы дарга, Хэл зохиолын хүрээлэнгийн ЭШТА, академич. boldl@mas.ac.mn

гэдэг үгийн бүтцэд тохиолдож байна. Үүнийг “*чиглэхийн тийн ялгалын нэг хэлбэр*”-ийг бас нэг хувилбар мөн гэж үзсэн байдаг (Рамстедт, 1957: 44-45).

Энд дурдсан баримтыг өмнө өгүүлсэн эртний түрэг хэлний өгөх чиглэхийн тийн ялгалын нөхцөлтэй харьцуулан үзвэл уг нөхцөл нь “-qa ~ -ya + -ru” гэсэн хоёр бүтээврээс нийлж бүтсэн нийлмэл нөхцөл гэж ухаарахад хүргэж байгаа юм. “Монголын нууц товчоо”-ны эх сурвалжаас үзвэл өмнө өгүүлсэн эртний түрэг хэлний адил өгөх болон чиглэхийн тийн ялгал харьцаа илэрхийлдэг нөхцөлүүд нэгэн үгийн бүтцэд угсран орж, өмнө дурдсан түрэг хэлний адил өгөх-чиглэхийн харьцаа заадаг байсны бүдэг боловч ул мөрийг ажиглаж болох байна. Уул дурсгал бичигт одоогийн бидний үзэж буйгаар бол өгөх-оршихын тийн ялгалын хэлбэр гэж үзэж байгаа “-da ~ -de (-ta ~ -te), -tur ~ -tür (-dur ~ -dür)” нөхцөлүүд байдаг бөгөөд тун сонирхолтой нь эдгээр бүтээврүүд нэгэн үгийн дараа “ger-te (§214), ger-tür (§65), mergid-te (§111), mergid-tür (§106)” гэх мэтээр нэг нь нөгөөгийнхөө байранд тохиолдож байгаа жишээ цөөнгүй байдаг.

Činggis qahan ... andada ügüle ke'en ilērün (МНТ §196)

Anda-tur qatquldan yadan yabula'a (МНТ §170)

Tatar-un Qargil šira... ger-te oroju (МНТ §214)

Temüjin Qasar qoyar ger-tür irejü ... (МНТ §16)

Байрлал хэл шинжлэлийн дэгийнхний онолоор бол чухамдаа нэг бүтээврийн хувилбарууд нь нэг нь нөгөөгийнхөө байранд тохиолдох учиргүй билээ. Үүнээс үзэхэд энэ хоёр нөхцөл нь лавтайяа хэлэхэд XIII зууны үед хоёр өөр тийн ялгалын харьцаа илэрхийлж байсан болохыг харуулж буй баримт гэж үзэж байна.

Temüjin Qasar qoyar ger-tür irejü üjin eke-de ögülerün (§76) – “*Тэмүжин, Хасар хоёр гэрт ирж (Өэлүн) үжин эхэд өгүүлрүүн*”

гэсэн өгүүлбэрт орсон “-tür”, “-de” нөхцөлийн утга, үүргийг анхааралтай үзвэл ger-tür irejü “*гэрт ирж*” гэхэд “*хаашаа*” гэсэн асуултад хариулагдаж, үйлийн болох чигийг зааж байхад eke-de ögülerün “*эхэд өгүүлрүүн*” гэхэд “*хэнд*” гэсэн асуултад хариулагдах тусагдахуун гишүүний харьцаа илэрхийлж байна гэж үзэх боломжтой.

Энд бидний авч үзэж байгаа бүтээврүүдээс зүг чиг заах “- га -- -ru -- -r”, өгөхийн тийн ялгалын “-da -- -de” бүтээврүүдийг түрэг монгол хэлний нийтлэгийн үүднээс тайлбарлах бүрэн үндэслэлтэй бол өгөх чиглэхийн буюу өнөөгийн бидний нийтээрээ нэрлэж заншсанаар өгөх оршихын тийн ялгалын харьцаа илэрхийлж буй “-tur -- -tur, -dur-- -dur -ийг дээрхийн нэг адилаар тайлбарлахад учир дутугдалтай, харин хэлний харилцан нөлөөллийн үүднээс тайлбарлагдах зүйл гэж үзэж байна. Түрэг монгол хэлний харьцааны асуудлыг үг зүйн түвшинд “Алтай хэлний онол”-ыг

зөвшөөрөгчид хийгээд үл зөвшөөрөгчдийн аль алиных нь судалсан бүтээлд энэ талаар тодорхой өгүүлсэн зүйл одоогоор тун ховор, тиймээс бид энэ үзэгдлийг нийтэд ойлгомжтой байдлыг нь харгалзан хэв шинжийн үүднээс авч үзэн тайлбарлах боломжтой авч үг зүйн хуулбарлалт гэж нэрлэвэл илүү оновчтой мэт санагдаж байна. Энэ нэр томъёоны талаар номын эрхэм нөхөд Та бүхэн маань мэргэн зөвлөгөөгөө өгөхийг чин зүрхнээсээ хүсье. Ийм үзэгдэл өөрөөр хэлбэл, хэл зүйн хэв шинжийн үүднээс тийн ялгалын хүрээнд авч үзвэл зохих зүйл зөвхөн өгөх-чиглэхийн жишээн дээр тохиолдож байгаа зүйл биш гэдгийг тэмдэглэх нь зүйтэй санагдана. Иймд бид эхлээд орхон бичгийн дурсгал хийгээд түүний хэл зүйг судалсан эрдэмтдийн бүтээлд бага зэрэг анхаарлаа хандуулахыг хүсэж байна.

Tabgacda adirilti (Т 2) “*Табагачаас тусгаарлаж...*”
 men... tabgaci qaganta bedizci kelurtim (Кт m 11) –“*Би... Табагачийн хаанаас чимэглэгч (хүн) авчрав.*”
 qara kolte sungusdimiz (Ктb 42) –“*Бид Хар нуурт тулалдлаа*”
 ida qalmisi qobranip jети juz bolti (Т.4) “*мод чулуунд (нуугдан) үлдсэн хүмүүс цугларч долоон зуун (хүн) болов*” г.м.

Эдгээр жишээнээс үзвэл нэрийн тийн ялгалын харьцаа илэрхийлж байгаа бүтээвэр нь хэлбэрийн хувьд ганц мэт харагдаж байгаа боловч өгүүлбэрт гүйцэтгэж байгаа үүрэг нь хоёр өөр байгааг бид хялбархан мэдэж болох байна. Өөрөөр хэлбэл эхний хоёр өгүүлбэрт орсон -да -та (-да -тэ) нь үйлийн болсон буюу болох орны харьцааг илэрхийлж байгаа бол сүүлчийн хоёр өгүүлбэрт орсон нөхцөлүүд нь үйлийн гарах орны харьцааг илэрхийлж байна. Иймээс түрэг судлалд үүнийг хоёр тийн ялгал бүр тодруулбал үйлийн болох орны харьцааг зааж “хаана” хэмээх асуултад хариулагдаж байгааг нь орны тийн ялгал, харин “хаанаас” гэсэн асуудалд хариулагдах хэлбэрийг нь орон-гарахын тийн ялгал гэж үзсээр байна (Кононов, 1980: 149). Монгол хэлний гарахын тийн ялгалын утга илэрхийлэх нөхцөлийг цуваа цагийн үүднээс нарийвчлан авч үзвэл бас иймэрхүү дүр зураг бууж болох жишээ баримт цөөнгүй байна. Иймд монгол хэлний хэл зүйн тогтолцооны талаар бүрэн дүүрэн баримт өгч чадах бичгийн хэлний найдвартай дурсгалуудаас цөөн жишээ авч үзье.

Baruŋin-qo'a-ča törüksen Alan-qo'a neretei ökin tere (МНТ §8)
 Bi ende-če qamsaju (МНТ §190)
 joči ča'adai qoyar jaqa-ča barilduŋu bayin бүкүй-түр... (МНТ §254)
 Temüŋin-ü qoyina-ča ebüsün-ü alurqai-bar mösgi-jü (МНТ §101)
 Duwa soqor Burqan Qaldun de'ere-ce qaraju... (МНТ § 5)
 Temujin umere-ce daldatcu qasar emune-ce daldatcu... (МНТ §77)

Гарахын тийн ялгалын утга илэрхийлж байгаа энэ бүтээврийн талаар манай ахмад эрдэмтэд өөрсдийн судалгааны бүтээлдээ авч үзсэн байдаг (Рамстедт, 1957: 156; Төмөртоого, 2002: 250). Харин уг харьцааг

илэрхийлдэг тийн ялгалын нөхцөл нь монгол хэлний хөгжлийн харьцангуй эртний шинжийг тусгасан монгол бичгийн хэлэнд -аа -- -её гэсэн хоёрхон хувилбартай байдгийг хэн бүхэн мэдэх билээ. Бидэнд илэрхий мэдэгдэж байгаа энэ хоёр бүтээврийг харьцуулан үзвэл юуны өмнө доорх зүйлийг хэлэх хэрэгтэй байна. Нэгдүгээрт: Уул бүтээврийн бүтцийг монгол бичгийн хэлнээ мөн уг харьцааг илэрхийлдэг нөхцөл бүтээврийн бүтэцтэй харьцуулан үзвэл энэ нь их л тодорхой харагдах бөгөөд бидний хувьд бол уул хоёр хэлбэрийн аль нь анхдагч хэлбэр нь юм бэ гэдэг асуудалд шууд хөтлөн очиж байна. Энэ асуудалд бид онцын эргэлзэлгүйгээр ГЭ гэсэн бүтэцтэй нь уул тийн ялгалын анхдагч хэлбэр, монгол бичгийн хэлэнд буй ЭГЭ нь хожуу үүссэн нийлмэл бүтээвэр гэж хариулж болно гэж бодож байна. Хоёрдугаарт: Өмнө үзүүлсэн жишээ өгүүлбэрүүдээс үзвэл уул нөхцөл бүтээврийг нэр үг, оноосон нэрээс гадна уламжлалт хэл шинжлэлийн нэр томъёогоор бол дайвар үгийн дараа, бүтэц хэл шинжээчдийн хэрэглэж буй нэр томъёогоор бол орон цагийн нэрийн дараагаар залгаж байгаа нь ихээхэн анхаарал татаж байна. Энэ бол бидний бодоход маш сонирхолтой зүйл. Үүнтэй холбогдуулан бид дахин тайлбар хийхийг хүсэж байгаа бөгөөд гэхдээ эдгээр саналууд маань урьдчилан хэлэхэд монгол үгийн бүтцийг бүтэц хэл шинжлэлийн аргаар туурвисан бүтээлүүдийн үр дүнд суурилсан гэдгийг хэлэх хэрэгтэй.

Энэ дэгийнхний үзэж буйгаар бол хэлийг судлахад дан ганц бодит баримтаар хязгаарлагдахгүй, шууд ажиглагдахгүй зүйлийг нь харьцаан дээр нь үндэслэн учир шалтгааны үүднээс тайлбарлаж болох давуу талтай ажгуу. *Гэрийн хойно нид пад гэх дуу гарав. Энэ уулын цаана гол урсдаг. Ширээний дээр ном байна. Өглөө эрт явна* гэх мэт өгүүлбэрт орсон гадна, цаана, дээр, эрт зэрэг үгсийн харьцааг нь өөрчлөхгүйгээр өөр үгээр солин хэлбэл *Гэрийн ард нид пад гэх дуу гарав, Энэ уулын цаад талд гол урсдаг, Ширээний нүдэнд ном байна. Өглөө таван цагт явна* гэх зэргээр орон цагийн нэрсийн бүрэлдэхүүнд орсон орны харьцаа илэрхийлсэн бүтээврүүд нь хэл зүйн хийсвэр харьцаа илэрхийлсэн утгаа бүрэн алдаагүй байгаагийн шинж гэж үзэж байна.

Өөрөөр хэлбэл дээрх өгүүлбэрт орсон орон цагийн утга илэрхийлсэн үгс нь бүгд өгөх оршихын тийн ялгалын харьцаа илэрхийлж буй нь тодорхой зүйл мэт санагдана. Хэрвээ бидний гарган тавьж байгаа таамаглал үнэн бол эндээс бид хэл зүйн харьцаа илэрхийлдэг бүтээвэр үг бүтээх дагавар болон хувирдгийг харуулсан тодорхой жишээ болно гэж бодогдоно.

МНТ-нд гарахын тийн ялгалын “-аа/-еёе, -даа/-деёе” нөхцөл бас бий бөгөөд илэрхийлэх утга нь орчин цагийн монгол хэлнийхтэй их л ойролцоо байна. Энгийн өгүүлбэрийн түвшинд гүйцэтгэх үүрэг нь ч ижилхэн байна.

Keltegei qada-dača naiman irgen-tur morilarun (МНТ §192)
... deger-e tenggeri-eёе jaya'atu töreksen... (МНТ §1)

ᠰан тамга-даᠰа (Дө.б. I.10)

Энэ бүтээврийг олонх судлаачид нийлмэл гэдэг талаар маргадаггүй санал нэгтэй байдаг бөгөөд одоогийн бидний үзэхээр эдгээр нөхцөлийн бүрэлдэхүүнд оролцож байгаа -а-- -е, -да-- -дэ нь тухайн үеийнхээ хэлэнд орны харьцаа илэрхийлдэг нөхцөл гэдэг нь илүүц баталгаа бараг шаардлагагүй биз ээ. Энэ байдлаас үзвэл гарах үйл нь орны харьцаа илэрхийлэх бөгөөд энэ нь гарах үйл нь тодорхой орон байртай холбоотойг харуулж буй баримт (Төмөртоогоо, 2002: 251) гэж үзэж болох юм. Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд магадгүй эртний монгол хэлэнд гарах харьцаа илэрхийлдэг гэж одоогоор бидний таамаглаж байгаа -ᠰа -- -ᠰе бүтээврийг зөвхөн орны утга илэрхийлдэг үгсийн дараа хэрэглэсэн байна. Энэ байдал нь өмнө дурдсан ёсоор -а-- -е, -да-- -де нөхцөл нь орны харьцаа илэрхийлдэг утгатай гэж бидний өмнө дурдсан зүйлийг давхар баталж буй хэрэг гэж үзэж болох буй за. Хэрвээ бидний энд гарган тавьж буй баримт алдаагүй нь үнэн бол XIII-XIV зууны үед гарахын тийн ялгал, орон-гарахын тийн ялгал гэж байсны ул мөр гэж үзэхэд тийм ч ноцтой алдаа болохгүй мэт санагдаж байна.

Гэвч энэ үзэгдэл бидний бодоход харьцангуйгаар нэлээд хожмын үе болтол үргэлжилсэн гэж үзэхээр баримт ч бас байна. Хэл зохиолын хүрээлэн дээр хийгдсэн “Монголын уран зохиолын дээж 108 ботийн цахим сан”-аас “гэр” гэдэг үг гарахын тийн ялгалаар хэлбэржсэн байдлыг авч үзвэл үзвэл -ээс (-аас -- -оос -- -өөс) хэлбэрийг авсан 919 жишээ тохиолдож байна. *Хоёр хар нохой хуцаж ирэхэд гэрээс настай авгай гарч нохойгоо хорин биднийг гэртээ оруулав (Дамдинсүрэн Ц. "Хоёулаа миний хүү")*. *Би данхтай цай тавагтай идээ гэрээс авчирч хөгшний өмнө тавив (Дашидооров С. "Тэнгэрийн дуу")*. *Цамбын гэрээс сөөнгөдүү жонгиносон дуутай хүн ерөөл хэлж байх дуудав (Түдэв Л. "Нүүдэл")*. Гэтэл “гэр” гэдэг үгийг -тээс (---таас -тоос -төөс) хэлбэрээр хувиргасан жишээ ердөө дөрөвхөн байна. Жишээ авч үзсэн өгүүлбэрүүдийг уран зохиолын ямар төрөлд буйг нь бас анхааран, утга зохиолын ангиллын үүднээс үзвэл бүгд эртний утга зохиол, мөн шинэ үеийн уран зохиолын эхэн үед хамаарагдах бүтээлүүд байна. *Чингис хаан өгүүлрүүн: - Хөвгүүдийн минь ахмад чи гэртээс анх гараад мөр сайтай явж хүрсэн газартаа хүн, морийг гарздаж зовоосонгүй, өлзийт ойн иргэнийг оруулж ирэв чи ("Монголын нууц товчоо") Ядахдаа гэртээс нь хүн ирдэггүй золг вэ?(Аюуш. Ши "Яг 18")*. *...би гэртээс үхрийн толгойг дэлдэх сүх хийгээд ямаа, хонь алах хутга авч ирсүгэй (Агваанхайдав "Үхэр, хонь, ямаа гурвын гэлэн тойнтотой хүүрнэсэн яриа")*. Энд бяцхан тайлбар хийх нь зүйтэй байх. Энд дурдсан бага боловч хэдэн жишээ нь орсон -таас -- -тээс хэлбэр нь бүгд орон - гарахын тийн ялгалын харьцаа илэрхийлж байна гэж үзэх боломжгүй ч эдгээр нөхцөл нь уйгуржин монгол бичгийн хамтаар монгол утга зохиолын хэлэнд уламжлан ирсэн, гэхдээ орон-гарахын тийн ялгалын утгаа алдаж зөвхөн гарахын тийн ялгалын харьцаа илэрхийлдэг үүрэг гүйцэтгэж буй хэрэг гэж үзэж байна. Тэгвэл яагаад өмнө дурдсан маягаар -ээс гэсэн

хэлбэрээр хэлбэржүүлж болоогүй юм бэ гэсэн асуулт гарна. Бидний бодоход энэ нь дундад эртний монгол хэлнээс монгол бичгээр дамжин орчин цагийн монгол хэлэнд уламжлагдан ирсэн хэрэг гэж бодож байна.

Бодит байдал ийм байгаа учир, эртний болон дундад эртний монгол хэлэнд нэрийн тийн ялгалын тогтолцоо ямар байсан бэ гэдэг асуудлыг дахин нарийвчлан үзэх шаардлагатай байна.

Хэл бол алгуурхан боловч өөрчлөгдөн хувьсаж байдаг маш нарийн тогтолцоотой нийгмийн үзэгдэл билээ. Хэлний хөгжлийн өөрчлөгдөн хувьсах энэ зүй тогтол бидний энд ярилцаж буй тийн ялгал, түүний ямар харьцаа илэрхийлдэг нөхцөлүүд дээр ч харагддагийн тодорхой жишээг Саяаны түрэг хэлнүүд болон орчин цагийн монгол утга зохиолын хэлэнд зүг чиг заах тийн ялгал шинээр бүрэлдэн тогтсон байдлаас бид тодорхой харж болно. Уг хэлнүүдэд чиглэхийн тийн ялгалын харьцангуй хожуу үед бие даан үүссэн учир уг харьцааг илэрхийлж байгаа бүтээврүүд нь өөр хоорондоо төдий л шууд холбоогүй байна.

Тув.	-же ~ -че	хоорайже чоруур “ <i>хот руу явах</i> ”, бажныче гирер “ <i>байшин руу орох</i> ”,
	-дыва ~ -диве	дагдыва “ <i>уул руу</i> ”, кижидиве “ <i>хүн рүү</i> ”,
	(-дува ~ -дүве)	аттува “ <i>тал руу</i> ”, хүндүве “ <i>нар луу</i> ”,
	-тыве ~ -диве	
	(-тува ~ -гүве)	
Уйг.-ур.	-γda ~ -gde	ewgede “ <i>гэр лүү(гээ)</i> ”,
	-γada ~ -gede	gem ortboγ:da “ <i>голын салаа руу</i> ”,
		me:sgede “ <i>голын өвөр лүү</i> ”,
Тув.-Тож.	-гыди ~ -гиди	дээргэди “ <i>тэнгэр лүү</i> ”,
	-кыду ~ -кидү	
	(-куду ~ -күдү)	

Эдгээр нөхцөлийг гарал зүйн үүднээс нь авч үзвэл янз бүр, тухайлбал, тува хэлэнд хэрэглэгдэж байгаа зүг чиг заах тийн ялгалын нөхцөл “-тыва (~ - тыве)” нь бусад түрэг хэлэнд “таба ~ тебе ~ табан ~ таман” гэх мэт олон хэлбэртэй хэрэглэгдэж байгаа дагавар үгтэй авианыхаа бүрхүүлийн хувьд ч өгүүлбэрт гүйцэтгэж байгаа үүргийнхээ хувьд ч тун ойролцоо байгаа нь тодорхой байна. Каз. тауга таман кетү “*уулын зүгт очих ~ уул руу очих*” (Базылхан, 1977: 295).

Энд өгүүлсэнтэй холбогдуулан монгол хэлний “*энэтээ, тэртээ, зүүнтээ, баруунтаа*” гэх мэт орны утга илэрхийлдэг үгийн талаар цөөн зүйлийг хэлмээр байна. Монгол үгийн харьцангуй эртний хэлбэрийг хадгалсан гэж үзэж байгаа уйгуржин монгол бичгээр эдгээр үгийг “*энэтээ*” гэдгийг enetege, “*тэртээ*” гэдгийг teretege гэж бичиж байсан байна. “*Голын цаадтаа гарах*” (Цэвэл, 1966: 774) гэхэд “-таа” нь “голын цаад этгээдэд гарах, голын цаад

Эртний түрэг хэлний хэл зүйн байгууллыг судалсан эрдэмтэд энэ үгийг өгүүлбэрт тодорхой утга илтгэхгүй иймээс өгүүлбэрийн гишүүн болохгүй гэж үзээд туслах үгийн айд хамааруулан үзсэн байна (Кондратьев, 1981: 125; Кононов, 1980: 202). Үгийн гарлын талаас авч үзвэл энэ үг нь монгол хэлний гудайх “юмны нэгэн этгээд хажуу тийшээ жишиж доошлох” (Цэвэл, 1966: 156) гэсэн утгатай үгтэй холбогдох нь бараг эргэлзээгүй зүйл мөн авч өгүүлбэрт гүйцэтгэх үүргийнхээ хувьд эртний түрэг хэлний qodī нь монгол хэлний “гудай-” гэдэгтэй биш, харин uruγu > уруу “налуу тэгш биш” (Цэвэл, 1966: 365) гэдэгтэй ойролцоо утга, үүрэг гүйцэтгэж байна. Бид МНТ-ноос дахин хэдэн жишээ авч үзье.

Burqan qaldun de'erece tünggelik qoruqan uru'u nigen bölög irgen newüjü oruγu ayisuqu-yi qaraγu ... (§5) – “Бурхан халдун дээрээс харвал Түнхлэг горхин уруу нэгэн бүлэг иргэн нүүж айсууг харж ...”,

Onan mören uru'u yorçijü talbiba. (§24) – “Онон мөрөн уруу зорьж одов.”, Merkid ulus selengge uru'u söni-de dürbeγü. (§110) – “Мэргэдийн улс шөнө дүрвэн зугтаахад” гэх мэт.

Монгол бичгийн хэлэнд “уруу газар”, “уулын уруу” гэх мэт холбоо үгийн бүрэлдэхүүнд орохдоо “uruγu” нь үгийн сангийнхаа бодит утгыг хадгалж байсан бол “jüg uruγu” гэхэд орсон бодит утгаа алдаад зөвхөн авианыхаа бүрэлдэхүүнийг хадгалсан, харин “qural tegüskel uruγu-a ойиратаγu bayina “хурал төгсгөл уруугаа ойртож байна” гэхэд хэл зүйн үлэмж хийсвэр харьцаа зааж байна (Лувсандэндэв, 1982: 1-2). Орчин цагийн монгол утга зохиолын хэлний “хөл рүү, гар луу, гэр лүү, толгой руу” гэхэд монгол бичгийн хэлний “uruγu” нь бүр өргөлт болон авианыхаа бүрхүүлийн тогтмол байдлыг бүрмөсөн алдаад өмнөх үгтэйгээ авиа зохицон зөвхөн зүг чиг заах тийн ялгалын харьцаа илтгэх нөхцөлийн үүрэгтэй болсон байна. Энд дурдсан зүйлээс үзэхэд орчин цагийн монгол хэл, тува хэлний тожийн аялгуу, уйгур-урианхай зэрэг хэлэнд буй зүг чиг заах тийн ялгал бүрэлдэн тогтсон ерөнхий зүй тогтолтой адил, нарийвчлан үзвэл магадгүй монгол хэлний нөлөөгөөр үүссэн гэж үзэж болмоор байна.

Ийм тохиолдол ганц үүгээр бүр тодруулан хэлбэл тийн ялгалын нөхцөлөөр хязгаарлагдахгүй юм. Түгээл тооны нэр үүсгэхдээ олонх түрэг хэлэнд үндсэн тооны нэрийн ард гийгүүлэгчээр төгссөн бол “-ar ~ -er”, эгшгээр төгссөн бол “-sar ~ -ser” хэлбэрийг залгадаг билээ. Монгол нутаг дахь орхон бичгийн дурсгалд түгээл тооны нэр ер тохиолддоггүй боловч эртний түрэг хэлний бусад дурсгалд тэмдэглэгдсэн байна.

bir birer “нэг нэгээр” (ДТС, 1969: 10).

üč ücer “гурав гурваар” (ДТС, 1969: 622).

Орчин цагийн түрэг хэлнүүдэд эгшгээр төгссөн үгийн дараа тохиолдох “-sar ~ -ser” хэлбэр нь тухайн хэлнийхээ авиан зүйн онцлогоос хамаарч “-gar

~ -rer, -sar ~ -ser, -lar ~ -ler” хэлбэртэй болсон байна.

Узб.	birer	“нэг нэгээр”, <i>ikirer ~ ekisir</i> “хоёр хоёроор”,
Башк.	bisa:r	“тав таваар”, <i>una:r</i> “арав арваар”,
Тат.	birer	“нэг нэгээр”, <i>oča:r</i> “гурав гурваар”.
Туркм.	dörter	“дөрөв дөрвөөр”, <i>beşer</i> “тав таваар”,
Хак.	törter	“дөрөв дөрвөөр”,
Чув.	perer	“нэг нэгээр”,
bisse:r		“гурав гурваар” (Щербак, 1977: 154)

Түрэг хэлнүүдэд түгээл тооны нэрийг илэрхийлэхдээ гарахын тийн ялгалаар үндсэн тооны нэрийг хэлбэржүүлдэг арга бас нэлээд түгээмэл байдаг байна (Щербак, 1977: 154-155).

Каз.	üster	“гурав гурваар”,
Ккалп.	yekiden	“хоёр хоёроор”,
Уйг.	birde	“нэг нэгээр”,
Кир.	ekiden	“хоёр хоёроор”,
Ш-уйг.	törtten	“дөрөв дөрвөөр”,
Алт.	ekiden	“хоёр хоёроор”,
Шор.	pesden	“тав таваар”

гэх мэт. Гэвч бас зарим түрэг хэлэнд үндсэн тооны нэрийг давтан түгээл тооны нэрийг үүсгэдэг байна.

Аз.	iki iki	“хоёр хоёроор”,
	bes bes	“тав таваар”,
Тув.	on on	“арав арваар” гэх мэт.

Монгол хэлний түүхэн баримтуудаас үзвэл түгээл тооны нэрийг хэрэглэх хүрээ нь нэлээд багавтар байна. Тухайлбал, МНТ-ноос үзвэл түгээл тооны нэр үүсгэх дагавар нь “-al ~ -el” гэсэн хэлбэртэй цөөн хэдэн үндсэн тооны нэрийн дараа орж, түгээл тоо үүсгэж байсан байна.

Tabun kö'üd-iyen jergelen sa'ulji ni'ji'el müsün ququlutqun ke'e'jü ökbe (§419) – “таван хүүхдээ зэрэгцүүлэн суулгаж хүн бүрд нэгжгээд мөс (сум буюу нарийн мод)-ийг хугал гэж өгвөл...” - ni'ji'el “нэгжгээд” < nige “нэг”.

Орчин цагийн монгол хэлнүүдийн баримтаас үзвэл уг хэлэнд түгээл тооны нэрийг доор дурдах хоёр аргаар гол төлөв үүсгэдэг байна. Үүнд: Үндсэн тооны нэрийг давтан сүүлчийнхийг нь үйлдэхийн тийн ялгалаар

хэлбэржүүлдэг.

Мон. “Зуу зуугаар өгвөл зүгээр сэн” (Л.Т),
Бур. арба арбаар “*арав арваар*” (БРС, 1973: 55),
Хал. нежэд нежэдээр цуврээд довтолж йовад – “*нэг нэгээрээ цувраад довтолж яваад*” (ГКЯ, 1983: 157).

Үндсэн тооны нэрийг давтан хэрэглэж, уул зүйлийг ижил хэмжээгээр түгээн олгосон утга илтгэж байна.

“*Турвууланд нь нэг нэг бичиг хийж өгөв*” (Л.Т) гэх мэт.

Монгол хэлэнд түгээл тооны нэр үүсгэдэг энэ аргыг түрэг хэлнүүдэд түгээл тоо үүсгэдэг аргуудтай харьцуулан үзвэл уул хэлнүүдийн хооронд ерөнхий зүй тогтол, тухайлбал, үндсэн тооны нэрийг давтах, үндсэн тооны нэрийг давтан сүүлчийнхийг нь үйлдэхийн тийн ялгалаар хэлбэржүүлдэг түгээмэл зүй тогтолтой байдаг боловч бас нэг хэл нь нөгөө хэлэндээ нөлөөлсөн зүйл байхыг ч тодорхой харж болно. Тухайлбал, уйгур-урианхай, цаатны хэлэнд үндсэн тооны нэрийг давтан, ард нь “bile” гэдэг үйл үгийг хэрэглэдэг задлаг арга байна. Түгээл тооны нэр үүсгэдэг энэ задлаг аргыг монгол хэлний нөлөөний үүднээс тайлбарлан хэлэлцэхийн урьд “bile” гэдэг туслах үйл үгийн талаар товч тайлбар хийе. Энэ үг эртний түрэг хэлнээ “bile, birle” гэсэн хоёр янзаар тэмдэглэсэн байна. Үүний “birle” гэдэг хэлбэр нь орхон бичгийн хэлнээ нэлээд элбэг тохиолдоно.

čača sengün sekiz tümen birle sünüsdim. - “*Чача сэнгүмийн найман түмэнтэй тулалдлаа би*” (БХ. 26),
Bilge Ton'yukuk boyla baγa tarkan birle ilteriš kaγan bolayin. - “*Цэцэн Тоньюкук би бойла тарканы хамтаар Илтеришийг хаан болоосой (хэмээн санах бөлгөө)*” (Тон. 6-7).

Эдгээр жишээнд бидний сонирхож байгаа “birle” хэлбэр нь хамтрахын харьцаа зааж байна. Кашгарын Махмудын “Түрэг хэлнүүдийн толь бичиг” гэдэг номд “*Зун өвөлтэй харгалдав*” гэсэн шад шүлэг байна (Малов, 1951: 310). Энэ жишээнд “bile” нь мөн л хамтрахын утга илтгэж байна. kišilik bile at körtürdi kiši? “*Хүнлэгээрээ нэрээ өргөв хүн*” (ДТС, 1969: 98) гэхэд “bile” нь дээрхээс арай өөр утга, тухайлбал, үйлийн зэвсэг, үйл хоёрын харьцааг зааж байна.

Уйгур-урианхай хэлэнд “bile” нь яг ийм харьцааг, өөрөөр хэлбэл, үйлийн зэвсэг, үйл хоёрын харьцааг илэрхийлдэг билээ.

Bo qaranda: bile men zeme biše:n. – “*Энэ харандаагаар би юм бичсэн*”.
Мөн үйлийн орны харьцааг зааж байна.
... daštıγ oruγ bile gelge:n. – “*... Чулуутай замаар ирсэн*”.

Ийм тохиолдолд уйгур-урианхай хэлний “bile” нь ихэнхдээ монгол хэлний үйлдэхийн тийн ялгалтай адил үүрэг гүйцэтгэж байна.
 men oŋɣoɕa bile geldim. – “*Би онгоцоор ирсэн*”,
 sen a’t bile čordingar wa. – “*Чи мориор явах уу*” гэх мэт.

Энэ үүргээрээ уул туслах үйл үгийн өгүүлбэрт гүйцэтгэх үүрэг бусад хэлнийхээс нэлээд ялгаатай байна. Чухам ийм учраас уйгур-урианхай хэлэнд түгээл тооны нэр үүсгэхдээ монгол хэлэнд түгээл тооны нэр үүсгэдэг загвараар, өөрөөр хэлбэл, үндсэн тооны нэрийг нь давтан, давтсан хоёр тооны нэрийн сүүлчийнхийг нь үйлдэхийн тийн ялгалаар хэлбэржүүлдэг хэл зүйн энэ загварыг түгээл тооны нэр үүсгэх арга болгон авсан гэж таамаглаж байна. eki ekibile “*хоёр хоёроор*” гэх мэт.

Нэрт монголч эрдэмтэн Л.Лигети “...түүхэн үүднээс харшуулах аргыг хэрэглэхтэй холбогдсон нийтэд илэрхий бэрхшээлээс гадна өөр нэг томоохон бэрхшээл байгааг алтай хэлний судлал анхааран үзэх ёстой. Энэ алтай хэлнүүд язгуур болсон нэгэн хэлнээсээ ялгаран гарснаасаа хойш өөр хоорондоо төдий л саланги хөндий биш хөгжиж ирсэн явдал болно. Харин эдгээр хэлээр хэлэлцэгч аймаг ястнууд аль эрт цагаас янагш бие бие рүүгээ өнө удаан хийгээд нягт батаар хутгалдан нийлэх нь олонтоо байсан билээ. Энэ нь алтайн зарим хэлний үгийн сангийн бүрэлдэхүүнд ч, хэл зүйн бүтцэд ч ул мөрөө яриангүй үлдээсэн байна” (Лигети, 1970: 325) гэжээ. Их эрдэмтэн чухам үнэнийг өгүүлжээ.

Алтай хэл судлалын хүрээнд багагүй чухал байр эзэлдэг түрэг, монгол хэлний харьцааны асуудлыг уг хэлнүүдэд буй нийтлэг зүйлийг нь гол болгон гарал зүйнхээ хувьд холбоотой гэх, эсвэл уг нийтлэг зүйлийг нь нэг хэлнээсээ нөгөө хэлэндээ үзүүлсэн нөлөө гэж тайлбарласаар нэлээд хугацаа өнгөрч, энэ хоёр эсрэг тэсрэг онолын аль нэгийг зөвшөөрч, нөгөөг нь үгүйсгэсэн бүтээл туурвил гарсаар байна. Гэвч энэ чухал шийдвэрлэх асуудлын талаар судлаачид нэгэн нэгдмэл байр сууринд хүрч чадсан ахул алтай хэл шинжлэлийн салбарт шийдлээ хүлээсэн олон олон тулгамдаж буй асуудал хэдийн шийдэгдсэн байх асан. Энд бидний задлан шинжилсэн баримтаас үзэхэд түрэг, монгол хэлний харьцааг уг хоёр эсрэг тэсрэг онолын аль нэгийг нь баримтлан нөгөөг нь үгүйсгэн тайлбарлах нь учир дутагдалтай, уг хоёр онолыг харгалзан үзэх шаардлагатай нь тодорхой байна. Энэ нь эдгээр эсрэг тэсрэг онолууд нь харилцан бие биеэ үгүйсгэсэн боловч бас харилцан бие биеэ нөхсөн шинжтэй гэдгийг харуулж байна. Өөрөөр хэлбэл, түрэг, монгол хэл нь гарал зүйнхээ үүднээс холбогдож болох авч бас бие биедээ үлэмж нөлөө үзүүлсэн, гэхдээ зөвхөн түрэг хэл монгол хэлэнд биш бас орчин цагийн түрэг хэлнүүдийг бүрэлдэн тогтоход монгол хэл багагүй чухал үүрэг гүйцэтгэжээ гэсэн дүгнэлт хийж болох юм.

Ном зүй

Базылхан, Б. (1977). *Казакша-Монголиа сөздик*. Улаанбаатар. [Bazilkhan, B. (1977). *Kazakh-Mongolian dictionary*. Ulaanbaatar.]

Болд, Л. (1995). МНТ-ны зарим үгийн гарлыг орхон бичгийн дурсгалаас сурвалжлах нь. Монгол-Солонгосын хамтарсан эрдэм шинжилгээ. IV. Улаанбаатар. [Bold, L. (1995). *Reporting some words origin of SHM from the Orkhon inscription*. Mongolian-Korean joint research. IV. Ulaanbaatar.]

Бурятско-русский словарь (1973). Составил К.М.Черемисов. Москва.

Гаадамба, Ш. (1990). *Монголын нууц товчоо судлалын зарим асуудал*. Улаанбаатар. [Gaadamba, Sh. (1990). *Some issues of Secret History of the Mongols research*. Ulaanbaatar.]

Грамматика калмыцкого языка. (1983). *Грамматика калмыцкого языка (фонетика и морфология)*. Ред. Г.Д.Санжеев. Москва.

Дамдинсүрэн, Ц. (1990). *Монголын нууц товчоо*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Damdinsuren, Ts. (1990). *The Secret History of the Mongols*. Ulaanbaatar. State publishing.]

Древнетюркский словарь. (1969). *Древнетюркский словарь*. Ленинград: Ред. Н.А.Никитина., Н.П.Ричкова.

Исхаков Ф.Г., Пальмбах. А.А. (1961). *Грамматика тувинского языка*. (фонетика и морфология). Ред. Е.И.Убрятова. Москва.

Кондратьев, В.Г. (1981). *Грамматический строй языка памятников древнетюркской письменности VIII-XI вв.* Ленинград.

Кононов, А.Н. (1980). *Грамматика языка тюркских рунических памятников (VII-IX вв)*. Ред. издательства Д.М.Насилов. Ленинград.

Лувсандэндэв, А. (1982). Хэлбичгийн ухааны зарим асуудал. Улаанбаатар: Шинжлэх Ухааны Академийн Хэвлэл. [Luvsandendev, A. (1982). *Some philological issues*. Ulaanbaatar: Printing house of the Academy of Sciences.]

Лувсандэндэв, А. (2017). *Монгол үндэстний утга зохиолын хэл бүрэлдэн тогтсон нь*. Эмх. Л.Болд, Б.Түвшинтөгс. Улаанбаатар: Онги бээс хэвлэлийн газар. [Luvsandendev, A (2017). *Formation of Mongolian literary language*. Comp. Bold L., Tuvshintugs B. Ulaanbaatar: Onggi beis printing.]


Малов, С.Е. (1951). *Памятники древнетюркской письменности (Тексты и исследования)*. Ответственный редактор А.Н.Кононов.

Рамстедт, Г.И. (1957). *Введение в алтайское языкознание. Морфология*. Москва.

Цэвэл, Я. (1966). *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Tsevel, Y. (1966). *A Brief dictionary of the Mongolian language*. Ulaanbaatar: State printing.]

Щербак, А.М. (1977). *Очерки по сравнительной морфологии тюркских языков*. Москва: Наука.

Элдэнтэй., Ардажав. (1986). *Монголын нууц товчоон (сийрүүлэл тайлбар)*. Хөх хот: Өвөрмонголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. [Eldentei., Ardajav. (1986). *The Secret history of the Mongols (transcription and explanation)*. Köke qota: Educational Publishing Committee in Inner Mongolia.]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.